



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/405

Арвайхээр сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйл, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн "Орхоны хөндийд Шинэ Хархорум хот байгуулах тухай" 07 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 287 дугаар тогтоолоор батлагдсан "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам"-ын 3.5.2, 3.9, 3.9.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлэн хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлэх, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах, түүх, соёл, аялал жуулчлалыг дэмжих зорилгоор Орхоны хөндийд "Шинэ Хархорум" хотыг байгуулах болсонтой холбогдуулан нөлөөлөлд өртөж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сонсох ажиллагааг зохион байгуулан, урьдчилан тохиролцож, хот байгуулах газрын хил заагийг 2023 оны 6 дугаар сарын 27-ны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулан, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан саналыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0784

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар  
сарын 06-ны өдрийн 4106 дугаар  
захирамжийн хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Ч.Гүнсэнхорол (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)

Г.Баясгалан (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Г.Одгэрэл (Хархорин сумын Засаг дарга)

Г.Түвшинтөр (Өвөрхангай аймгийн Ерөнхий архитектор)

М.Эрдэнэболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Г.Цэвэлмаа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар зохион байгуулалт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

С.Аравзайлхам (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын чанарын хянан баталгаа газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

С.Зоригтбаатар (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Геодези, зураг зүй хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Т.Ариунболд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)